



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2024 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 07

Номгон

Г

Г

Төсвийн орлого нэмэгдүүлэх, татвар хураалтын
ажлыг эрчимжүүлэх тухай

Баянхонгор аймгийн орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл 2024 оны 8 дугаар сарын байдлаар сумын дүнгээр биелж байгаа боловч татварын нэр төрлөөр тасарч, 2024 оны төсвийн өөрчлөлтөөр татварын орлогын хэмжээг нэмэгдүүлэн баталсан тул улс, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг татварын нэр төрөл тус бүрээр жигд ханган биелүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ДААЛГАХ нь :

Нэг. Сумдын Засаг дарга нарт

1.1. Татварын ерөнхий хууль болон бусад холбогдох хуулийн хэрэгжилтийг хангах замаар Улс, орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг татварын нэр төрөл тус бүрээр шат шатанд нь жигд ханган биелүүлэх.

1.2. Татварын урьд онуудын өрийг барагдуулах, шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэх.

1.3. Татварын улсын байцаагч болон татвар, төлбөр, хураамжийг хураахад хамтран ажилладаг/ Санхүүгийн албаны дарга мэргэжилтэн, Байгаль орчны улсын байцаагч, газрын даамал, цагдаагийн хэсгийн төлөөлөгч/ албан хаагчдын ажлын уялдааг сайжруулан сум орон нутгийн хэмжээнд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж тасраад буй орлогуудад анхаарч ажиллах.

1.4. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, орон нутгийн зам ашигласны хураамжаа төлөөгүй иргэн, хуулийн этгээдүүдтэй нэг бүрчлэн холбогдож татвар, хураамжийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлэх болон гадны бүртгэл, дугаартай автотээврийн хэрэгслийг орон нутагтаа бүртгүүлж татвар хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх.

1.5. Засаг дарга, газрын албанаас олгосон газар эзэмших, ашиглах эрх, эдгээрийн нэгж, талбаруудын мэдээллийг газрын кадастрын мэдээллийн санд бүрэн бүртгэж, цахимжуулахад онцгой анхаарч, газрын төлбөрийн ногдуулалтыг бүрэн хийж дуусгах.

1.6. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрын дуудлага худалдааг яаралтай зохион байгуулж, тухайн жилийн орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэх.

642402011

1.7.Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг ИТХурлаараа хэлэлцүүлэн батлуулж, уг татварын ач холбогдлыг малчдад сурталчлан таниулж, орлогыг бүрэн төвлөрүүлэх.

1.8.Сумдад үйл ажиллагаа явуулж байгаа ус, рашааны нөөцийг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглагч иргэн этгээд / уурын зуух, халуун усны газар, рашаан сувиллын газар, эсгийн, тоосго, блокны үйлдвэр, үдийн хоол хөтөлбөрт хүнс нийлүүлэгч аж ахуйн нэгж гэх мэт/-ийг бүртгэлжүүлж ус ашиглуулах дүгнэлт гаргуулан, усны нөөц ашигласны төлбөр ногдуулж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр Бөөнцагаан Оrog нуурын сав газрын захиргаа, Байгаль орчны газар, Татварын алба, ус ашиглагчийн үйлдвэр, үйлчилгээнд ашигласан усны хэмжээг бодитоор тодорхойлон, төлбөрийн орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлэхэд хамтран ажиллах.

1.9.Түүхэн дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газруудыг хамгаалалтанд авч, хуулийн хүрээнд төлбөр хураамжтай болгох.

1.10.Суманд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглан үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжээс түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хууль тогтоомжийн хүрээнд ногдуулан сумын төсөвт төвлөрүүлэх.

1.11.Хог хаягдлын хураамжийг бүрэн төвлөрүүлэхэд анхаарч, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.

Хоёр. Аймгийн Татварын газарт:

2.1.Төрийн бусад байгууллагуудтай хамтран хөрөнгийн татвар төлөгчдийн бүртгэл мэдээллийн зөрүүг арилган бүртгэлд хамрагдаагүй татвар төлөгчдийг хамруулах.

2.2.Тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагааг шинэчлэн зохион байгуулах ажлын хүрээнд сүүлийн 4-5 жилийн хугацаанд техник хяналтын үзлэгт хамрагдаагүй, татвар хураамж төлөөгүй, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, авто тээврийн хэрэгслийг бүртгэлийн сангаас хасах.

2.3.Аймаг, сумдын төсвийн орлогын гүйцэтгэлийг сар, улирлаар Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын Санхүүгийн албатай хамтран хянаж, Сангийн яамны /И-хуулга/ -тай тулган баталгаажуулж мэдээний үнэн зөв байдлыг ханган ажиллах.


Гурав. Хяналт, мэдээллийн талаар:

3.1. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2024 оны 10 дугаар сарын 1-ний дотор, хэрэгжилтийн тайланг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Санхүү, төрийн сангийн хэлтэст албан бичгээр ирүүлэх.

3.2. Албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулах загвар маягтыг хавсралтаар баталсугай.

3.3.Албан даалгаврыг хэрэгжүүлэхэд зохион байгуулалтын арга хэмжээ авч идэвхийлэн ажиллахыг сумдын Засаг дарга нар, аймгийн Татварын газар / С.Рэнцэндагва /-

т, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Байгалмаа/-т үүрэг болгосугай.



Аймгийн Засаг даргын ~~2014~~²⁰¹⁵-ны 09 дүгээр сарын
24-ний өдрийн 08 дугаар албан даалгаврын
хавсралт

АЛБАН ДААЛГАВРЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/Д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин
1	2	3	4	5	6

ооо